ГАДНА ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 01 дүгээр сарын 21

Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, Моносын уулзварыг Толгойтын авто замтай төмөр зам дээгүүр гүүрэн байгууламжаар холбох ажлын хүрээнд гадна цахилгаан хангамжийн ажлын зураг боловсруулах.

Гүйцэтгэх ажил:

- Тендерт оролцогч нь батлагдсан техникийн нөхцлийн дагуу 0.4кВ, 10кВ, 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам, тулгуур, дэд өртөө зөөх ажлын зургийг боловсруулна.

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

1. ***Техникийн чадвар, мэргэжлийн шаардлага***

- Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байх /ТЗ-8.4 0.4-110Кв болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах/
- Зураг төсөл боловсруулах чадвартай инженерийн багтай байх
- Цахилгааны инженер-3 байх, үүнээс зургийн мэргэшсэн инженер-1, зөвлөх инженер-1 байх
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм" болон цахилгаан байгууламжийн стандарт, норм дүрмүүдийг дагаж мөрдөх

2. ***Аюулгүй байдал, баталгаажуулалт***

2.1 Өндөр хүчдэлийн аюулгүй ажиллагаа

- Ажлын зураг нь трассын дагуух агаарын шугам, шон, кабелийн аюулгүй зай, хамгаалалт болон техникийн нөхцлийн дагуу тусгаарлалтын хэмжээг дагаж гаргасан байх.

2.2 Баталгаажуулалт

- Зураг, тооцоог цахилгааны зохицуулагч байгууллагаар зөвшилцөх, магадлалаар баталгаажуулах.

ХЯНАСАН:
Хот төлөвлөлт, судалгааны институт
ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер Б.ЛХАГВАСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
Хот төлөвлөлт, судалгааны институт
ОНӨААТҮГ-ын ДБХ-ийн дарга И.МЯГМАРСҮРЭН